

ЭЛЭГДЭЛ БОЛОН ҮРЖИЛ ШИМЭЭР ДОРОЙТОН АТАРШИЖ ХАЯГДСАН ТАЛБАЙГ ТАРИМАЛ БЭЛЧЭЭР БОЛГОХ

Б.Баатарцол, С.Сайханцэцэг

Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн

e-mail: saikhantsetseg@gmail.com

ХУРААНГУЙ

Хөрсний үржил шим нь доройтсон, элэгдэж эвдэрсэн цаашид тариаланд ашиглахад хүндрэлтэй атаршсан газрыг олон наст ургамал тариалж бэлчээрт ашиглаж хөрсний үржил шимийг сэргээж, сайжруулах зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ. Атаршсан талбайн хөрс боловсруулах аргыг сонгож, түүний хөрс ургамалд үзүүлэх нөлөөг илрүүлэв. Боловсруулсан талбайд нөмрөг таримлын доор олон наст ургамал тарих боломжийг илрүүлэв. Атаршиж хаягдсан талбайд олон наст таримал ургамал тариалж байгалийн зүй тогтоцод шилжүүлэхийн дээр хөрсийг бордсоноор уг талбайн үржил шимийг тогтворжуулж экологийн тэнцвэрт байдлыг хангах нь судалгааны ажлын шинэлэг тал болно.

Тариалан эрхлэх боломжгүй, олон жил ашиглагдаагүй орхигдсон талбайд олон наст тариалснаар уг талбай байгалийн тогтоцод шилжих бөгөөд бэлчээрийн ургамлын төрөл зүйлд олон наст буурцагт ургамлын эзлэх хэмжээ нэмэгдэнэ. Бэлчээрийг ийнхүү сайжруулснаар мал аж ахуйн тэжээлийн хангамж нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.

ТҮЛХҮҮР ҮГ: Хөрс, атар, бэлчээр, ургац, талбай

ОРШИЛ

Атрын III аяны хүрээнд төр засгийн дэмжсэн бодлого, хөрөнгө оруулагчдын болон тариалан эрхлэгчдийн хүчин чармайлтаар сүүлийн 4 жилийн дүнгээр нийт 394.7 мянган га атаршсан Хэдийгээр сүүлийн жилүүдэд атаршсан болон орхигдсон талбайг буцааж тариаланд ашиглах хэмжээ эрс нэмэгдсэн боловч цаашид нэмж ашиглах боломжтой талбайн хэмжээ улсын хэмжээнд 338.4 мянган га байгаагаас тариалангийн гол бүс нутаг болох Сэлэнгэ аймагт 9.7 мянган га талбай байхад баруун болон зүүн бүс нутагт тухайлбал Дорнод аймагт 45.8,

болон орхигдсан талбайг тариалангийн эргэлтэд шилжүүлснээр 2011 оноос эхлэн улаан буудайн улсын хүнсний хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд үйлдвэрлэл явуулах нөхцөл бүрдээд байна. Увс аймагт 11.7, Төв бүсийн Архангай, Өвөрхангай аймгуудад нийлээд 64 мянган га байна. Онолын хувьд атаржуулж орхисон талбай 25-30 жилд дахин сэргэдэг бол уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтын улмаас 40-50 жил болсон талбайд бэлчээрийн ургамал одоо болтол орж ирэхгүй байна. Иймээс түүнийг зориудаар дахин сэргээх шинэ арга боловсруулж газар

тариаланд ашиглахад боломжгүй талбайнуудыг таримал ургамал тариалж бэлчээрт ашиглах шаардлагатай байна. Тариалангийн талбайн хөрс элдэншүүлэлт, уриншийн технологийн талаар арвин их судалгааны дүн хуримтлагдаж одоо нэмэгдсээр байгаа боловч атар газрыг элдэншүүлэх талаар ховор, атаршсан газрыг элдэншүүлэх талаар тухайлан судалсан нь бүр ч ховор байдаг ажээ. Тариалангийн системийн түүхэнд атаршуулан өнжөөх систем гэж байсан боловч энэ нь эрт орхигдож одоо нэгэнт хэрэглэхээ больжээ. Оросын эрдэмтдийн

/С.А.Воробьев 1970 нар/ 1970-аад оны үед бичсэнийг үзвэл атаршсан газрыг элдэншүүлэх нь атар газар юмуу олон наст өвс тариалж байсан пласт талбайг элдэншүүлэхтэй ижил юуны өмнө хөрслүүртэй анжисаар аль болох гүн хагалаад ширэгжсэн үеийг бутлахын тулд цант багажаар олон дахин хэрчихийг зөвлөсөн байдаг. Казакстаны тариаланд 1990 оноос хойш орхигдсон талбайнуудаа ашиглаж ихэвчлэн, тэжээлийн олон наст өвс тариалан үржил шимийг сэргээж байгаа мэдээ байна.

ЗОРИЛГО

Салхины элэгдлээс улбаалан үржил шимийн доройтолд орсон, цаашид тариалангийн үйлдвэрлэлд ашиглахад эрсдэлтэй талбайд олон

наст ургамал тариалж таримал бэлчээрт шилжүүлэх

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Туршлага нь уринш бэлтгээд буудай тариалсан, элдэншүүлэгдсэн гуурстай талбайд дараа жил нь 6 сард зуны борооны үеийг угтуулан хошуу будааны нөмөрт шар царгас тариалав. Нөмрөг үүсгэгч ургамлын зориулалтаар Хошуу будааны Сельма сортыг 6 сарын 20-нд 1 га

талбайд 120 кг/га нормоор 6 см гүнд тариалж, тухайн өдөрт нь багтаан уг тарилтын хөндлөн чиглэлд шар царгасны *Medicago Falcata* сортыг 1 га талбайд 10 кг/га үрийн нормоор тариалж булдсан.

Хүснэгт 1

Таримал	Туршлаганд хэрэглэсэн үрийн чанар			1000 үрийн жин,г	ААХЧ,%
	Лаб. Соёололт,%	Үрийн цэвэршилт,%			
Шар царгас-/ <i>Medicago Falcata</i> /	98.0	95.0		2.5	93.1
Хошуу будаа /Сельма/	98.0	96.0		32	94.1

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2012 онд 5-р сард нийт 51.9 мм тунадас унасаны 50.4 мм буюу 97.1% нь 2-р 10 хоногт үүнээс 47.4 мм нь 5-р сарын 21-22 нд оржээ. Мөн 6-р сард хур тунадастай өдрийн тоо олон, түүний

хуваарилалтжигд байсаннь таримлуудын үр богино хугацаанд жигд соёолж гарах нөхцөлийг бүрдүүлэв.

Хүснэгт 2

Таримал	Тариалсан таримлуудын хээрийн цухуйц, ш / ам метр			Дундаж
	1	2	3	
Шар царгас-/ <i>Medicago Falcata</i> /	16	21	8	15
Хошуу будаа /Сельма/	143	137	161	147

Соёлолтын дүнгээс үзвэл царгасны нэгж талбайд ургах тоо нь бага харагдаж байгаа боловч олон наст таримал тул ургах явцдаа бэхжиж бутлаж ургадаг тул харьцангуй сайн үзүүлэлт төдийгүй нийт талбайд хээрийн цухуйц нь жигдбайв. Жигд хэвийн цухуйсан нөмрөг таримал болох хошуу будаа нь эрчимтэй ургаж 8 сарын сүүлээр хадаж ногоон массын ургац

тооцоход хөрс элдэншүүлгийн дам нөлөөнөөс хамаарч нэг ам метр талбайд 552-602 г буюу нэг га талбайгаас 55.2-60.2 ц/га ногоон массын ургац өгч үүнийг хатааж өвсөн шилжүүлэхэд жингээр байгалийн хадлангаас даруй 7.8-8.5 дахин их, сайн чанарын ургац хураан авах боломжтой нь харагдаж байна.

Хүснэгт 4

Нөмрөг таримлын ногоон масс ба өвсний ургац, г/ам метр

№	Хувилбар	Нойтон жин, г			Хуурай жин, г		
		Давталт		Дундаж	Давталт		Дундаж
		I	II		I	II	
1	Хими	472	632	552	421	585	503
2	Хосолсон	549	614	581.5	492	569	530.5
3	Механик	611	593	602	558	533	545.5

ДҮГНЭЛТ

Нөмрөг таримал тариалснаар олон настуг нарны цонолтоос хамгаалахын зэрэгцээ намар

хадсанаар байгалийн хадлангаас даруй 7.8-8.5 дахин сайн ургац хураан авах боломжтой байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Аваадорж Д, Баасандорж Я, 2001, Монгол орны хөрсний элэгдэл эвдрэл ба түүнтэй тэмцэж буй арга зам, илтгэл
2. Баатарцол Б, 1997, ТТБ-д уриншийн хөрс боловсруулалтыг цомхотгох боломж, автореферат
3. Бямбажав Н, 2006, Газар тариалан, х 154-159
4. Воробьев С. А. И др, 1977, Земледелия, стр 338 – 346
5. Даваадорж Г. Нар, 2002, Хөрс хамгаалах технологи, х 110
6. Мижиддорж Ж. Нар, 2001, Уриншийн талбайг хавж элдэншүүлэх зөвлөмж,

POSSIBILITIES MAKING CROP PASTURE IN THE EROSION AND DECREASE FERTILITY ABANDONED LAND

B. Baatartsol, S. Saikhantsetseg

The research was conducted for improving soil fertility which deteriorated and hard to utilize for agriculture as planting perennials and using as pasture in fallow fields. Method that cultivates the fallow field soil was chosen and its effect to soil and plants was revealed.

A novelty of the research is to keep ecological balance and fertility was resulted by planting perennials in fallow field, rebuilding to natural creation and fertilizing.

Planting perennials in unable to take crop and fallow field will be a reason of increasing percentage of the pasture pieces such as perennials and leguminous plants. Improving quality of pasture brings better situation for supply of fodder in animal husbandry.